



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 5/28

Улаанбаатар хот

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/12438 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлыг томилогдох хүртэлх хугацаанд менежер Бүрэнжаргалын Мөнхбаяраар тус газрын захирлын албан үүргийг 2024 оны 8 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Б.Мөнхбаярт хавсран гүйцэтгэсэн албан тушаалын үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдлийг тооцож сар бүр олгохыг Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч Д.Нямлхагвад зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

1720011089